



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 01 сарын 09 өдөр

Дугаар 1/18

Улаанбаатар хот

Улаанбаатар хотын суурьшлын бүсийн
хязгаарыг тогтоох тухай

Улсын Их Хурлын 2013 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичиг”-ийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2, Хот байгуулалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.5-д заасныг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улаанбаатар хотын суурьшлын бүсийн хязгаар /тиг гортиг/-ыг 35206 га талбайгаар тогтоож 1 дүгээр, эргэлтийн цэгүүдийн координатыг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Энэ захирамжийн 1, 2 дугаар зүйлд заасан бүсэд хот байгуулалтын тухай болон газрын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулж, явц, үр дүнг тухай бүр танилцуулж ажиллахыг Нийслэлийн Хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний газар /Э.Анар/, Нийслэлийн Газрын алба /Э.Болорчулуун/-нд тус тус үүрэг болгосугай.

3. Энэ захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын ногоон хөгжил, агаарын бохирдлын асуудал хариуцсан орлогч Ж.Батбаясгалан, Нийслэлийн Засаг даргын дэд бүтэц, гэр хорооллын хөгжлийн асуудал хариуцсан орлогч П.Баярхүү нарт болон Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар /Л.Эрдэнэчулуун/-т тус тус даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ




С.БАТБОЛД

ГАЗРЫН БАЙРШИЛ

ТАЛБAYН ХЭМЖЭЭ

Улаабаатар хотын Сонгинохайрхан, Баянзүрх, Баянгол, Чингэлтэй, Сүхбаатар, Хан-Уул дүүрэг

35206 ГА



Тусгаг : WGS 1984 UTM Zone 48N

Масштаб 1: 200,000

Таних тэмдэг



НИЙСЛЭЛИЙН ХОТ ТӨЛӨВЛӨЛТ, ЕРӨНХИЙ
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГАЗАР

УЛААНБААТАР ХОТЫН БАРИЛГАЖИХ ХЭСГИЙН НУТАГ
ДЭВСГЭРИЙН ХИЛ ХЯЗГААР /ТИГ ГОРТИГ/

- | | |
|---------------------|---------------|
| Барилгажих хил | Эдэлбэр газар |
| Авто зам, талбай | Хорооны хил |
| Одоо байгаа барилга | Гол |